Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасны дагуу дотоод хяналт шалгалт хийх дотоод хяналтын зөвлөлийг Засаг даргын тамгын газрын даргын 2022 оны 02 сарын 17-ны өдрийн А/04 тоот тушаалаар томилсон байна. Дотоод хяналтын зөвлөл нь 2022 онд дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж батлуулаагүй, дотоод хяналтыг хийж хэрэгжүүлээгүй байна.

Тус байгууллага нь аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн тул тус бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах шаардлага тулгараад байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл, төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна гэж үзлээ. Гэхдээ санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэхдээ Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудын дагуу иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна. Тухайлбал: Санхүүгийн тайлангийн толилуулгыг бэлтгээгүй, төсвийн гүйцэтгэлийн тайлбар тодруулга хийгээгүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 71.1 сая төгрөгөөр буюу 2.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Дансны авлага	0.2	3.7	3.5
Бараа материал	103.6	110.2	6.6
Үндсэн хөрөнгө	3,175.3	3,094.1	(81.2)
Биет бус хөрөнгө	87.7	87.7	(0.1)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,366.9</b>	<b>3,295.8</b>	<b>(71.1)</b>
<b>Эздийн өмч</b>	<b>3,010.3</b>	<b>3,010.3</b>	-
-төрийн	3,010.3	3,010.3	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	193.1	193.1	-
Хуримтлагдсан үр дүн	161.8	92.4	(69.4)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,366.9</b>	<b>3,295.8</b>	<b>(71.1)</b>

- Татварын хэлтсээс 3.7 сая төгрөгийн авлагатай байгаа ба харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулсан байна.
- Бараа материал данс нь тайлант онд 121.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 115.0 сая төгрөгөөр хасагдсан байна. Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 110.2 сая төгрөг болж өмнөх оноос 6.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 81.2 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд:

Төсвийн хөрөнгөөр 26.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, ОНХСангийн хөрөнгө, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 68.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр шилжүүлэн авч, нийт 94.8 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж, тайлант оны элэгдлийн зардал 176.2 сая төгрөгөөр хасагдсан байна.

- Хуримтлагдсан үр дүн данс 69.4 сая төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 548.4 сая төгрөгөөр төлөвлөж санал хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн саналаас 120.7 сая төгрөгөөр нэмж орон нутгийн төсвөөс санхүүжих дүнг 669.1 сая төгрөгөөр баталсан байна. Сумын ИТХ-ын 2022 оны 07 дугаар сарын 07-ны 14 дугаар тогтоолоор тус байгууллагын төсвийг 87.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 756.8 сая төгрөг болгож тодотгон баталсан байна. Тус байгууллагын 2022 оны төсвийг 2021 оны төлөвлөгөө гүйцэтгэлтэй харьцуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Үзүүлэлт	2022 оны батлагдсан төсөв	2021 оны		Төлөвлөгөөтэй харьцуулсан дүн	/сая төгрөгөөр/ Гүйцэтгэлтэй харьцуулсан дүн
		төлөвлөгөө	гүйцэтгэл		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	756.8	867.2	849.7	110.4	92.9

**Хүснэгтээс харахад:** 2022 оны төсвийг батлахдаа 2021 оны төлөвлөгөөнөөс 110.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлээс 92.9 сая төгрөгөөр хасаж баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 10

зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр 756.8 сая төгрөгийн төсөв баталсан ба үүний 238.2 сая төгрөг нь аймгийн төсвөөс өгсөн санхүүгийн дэмжлэг, 427.9 сая төгрөг орон нутгийн төсвөөс, урьд оны үлдэгдлээс 90.7 сая төгрөгөөр санхүүжихээр төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрт 756.8 сая төгрөгийн эх үүсвэрийг хүлээн авсан ба батлагдсан төсвөөс 60.5 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн үйл ажиллагааны нийт зардлын гүйцэтгэл 546.8 сая төгрөг буюу 91.6 хувь, хөрөнгийн зардлын гүйцэтгэл 149.4 сая төгрөг буюу 93.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант оны төсвийн үлдэгдэл 60.5 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7<sup>1</sup> дахь заалттай нийцэж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 12.2 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 43.4 сая төгрөгийг нэмэлт дансанд орлогоор хүлээн зөвшөөрсөн байна.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 9.6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 22.5 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 8.1 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. 15.3 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн 21.2 сая төгрөгийн зөрчил, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах тухай өмнө жилийн Санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилаагүй зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангиллыг зөрчихгүй байх тухай 2 зөвлөмжийг хүргүүлж байна.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мөнх-Оргил, гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 3/69 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

<sup>1</sup> Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 790.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 15.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 12.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Хилийн цэсийн самбар, хаалгыг нийт 21.2 сая төгрөгөөр барьж байгуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1<sup>2</sup> дэх заалтыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Албан шаардлага хүргүүлэв.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 3 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгаж байна.

Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2022 онд байршуулсан мэдээллийг түүвэрлэн хянаж үзэхэд:

- Таван саяас дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллээс 9 удаагийн 279.0 сая төгрөг, цалингаас бусад 5 саяас дээш үнийн дүн бүхий орлогын мэдээлэл 12 удаагийн 349.3 сая төгрөг, зарлагын 8 удаагийн 91.9 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.
- Тайлант оны 4 дүгээр сард Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийг огт мэдээлээгүй
- хагас, бүтэн жилээр оруулах мэдээллээс байгууллагын батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төслөөс бусад бүх мэдээллийг мэдээлээгүй байна.

Эдгээр нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.4, 6.1.5, 6.4.3, 6.4.4, 6.4.5, дахь заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<sup>2</sup> хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах;

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3010.1 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмжийг өгч, 168.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	3010.1	3	3010.0	
Албан шаардлага	1	168.2	1	168.2	100
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>3178.3</b>	<b>4</b>	<b>3178.2</b>	<b>80</b>

Төсвийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж, аудитын байгууллагад ирүүлж байх, Цаашид хэрэгцээ шаардлагагүй бараа материал худалдан авч их хэмжээний нөөц үүсгэхгүй байхаар үйл ажиллагаагаа зохион байгуулах нь зүйтэй байна. Улсын бүртгэлийн гэрчилгээний дүрмийн санд өөрчлөлт хийлгэх, Шилэн дансны тухай хууль, журмыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах 4 зөвлөмжийн биелэлт 80% хэрэгжүүлж ажилласан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар давтан шалгах онцгой асуудал байхгүй байна.

### 5. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэлийн хүрээнд үндсэн хөрөнгө, бараа материал, урсгал зардал болон Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзээд 23.8 сая төгрөгийн алдааг аудитын хугацаанд залруулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлээгүйгээс 21.2 сая төгрөгийн зөрчил болон Шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд албан шаардлага хүргүүлж, бусад зөрчилтэй асуудалд 2 зөвлөмжийг хүргүүлж байна.

#### 5.1 Залруулсан алдаа

Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 23.8 сая төгрөгийн залруулга хийсэн болно. Үүнд:

1. Тайлант оны элэгдлийн зардлыг 6.4 сая төгрөгөөр дутуу тооцож тайлагнасан;
2. Нөөцийн бараа данснаас 12.4 сая төгрөгийн нөөцийн өвс худалдан борлуулсан боловч өвсөө зарлага гаргаагүй үлдэгдэлтэйгээр тайлагнасан;
3. Багийн барилгын зураг төсөв 5.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгүүлсэн. Зураг төсвийг бүртгэлд тусгаагүй;

#### 5.2 Төлбөрийн акт

Жаргалант сумын засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

#### 5.3 Албан шаардлага

1. Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин 21.2 сая төгрөгөөр хилийн цэсийн

самбар, хаалга барьж байгуулахад зарцуулсан байгаад албан шаардлага хүргүүлэхээр шийдэж байна.

2. Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд:

- Таван саяас дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллээс 9 удаагийн 279.0 сая төгрөг, цалингаас бусад 5 саяас дээш үнийн дүн бүхий орлогын мэдээлэл 12 удаагийн 349.3 сая төгрөг, зарлагын 8 удаагийн 91.9 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.
- Тайлант оны 4 дүгээр сард Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийг огт мэдээлээгүй
- хагас, бүтэн жилээр оруулах мэдээллээс байгууллагын батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төслөөс бусад бүх мэдээллийг мэдээлээгүй байна.

Эдгээр нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.4, 6.1.5, 6.4.3, 6.4.4, 6.4.5, дахь заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй тул албан шаардлага хүргүүлсэн болно.

#### 5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

Байгууллагын дотоод хяналт хариуцсан нэгж нь байгууллагын дотоод хяналт хийх ажлын төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж илэрсэн алдаа зөрчилд зөвлөмжийг өгч ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 дахь заалттай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөг батлуулахдаа Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 4.1-д заасан чиглэлийг баримтлах, алдаа зөрчлийг арилгах хугацаатай зөвлөмжийг өгч, хэрэгжилтийг тооцож ажиллах

##### 2. Зардлын эдийн засгийн ангиллын талаар:

###### Илрүүлэлт:

Тайлант онд Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 1.9 сая төгрөгийг байгууллагын халаалтын зардалд, бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн зүйлс худалдан авах зардлаас 0,8 сая төгрөгийг мотоциколийн үнийн үлдэгдэлд төлсөн байна.

###### Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар журмыг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Данс бүртгэлд бүртгээгүй	3	23.8	3	23.8			3	23.8				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>23.8</b>	<b>3</b>	<b>23.8</b>			<b>3</b>	<b>23.8</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин Хилийн цэсийн самбар, хаалга барьсан	1	21.2			1	21.2						
Байгууллагын дотоод хяналтын төлөвлөгөө батлуулж, хяналт шалгалт хийгээгүй.	1	-					1	-				
Зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн.	1	2.7					1	2.7				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>23.9</b>			<b>1</b>	<b>21.2</b>	<b>2</b>	<b>2.7</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/					
			Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээлэл оруулаагүй.	1	720.3			1	720.3		
Нийт дүн	1	720.3			1	720.3		

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:  
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
 АНХАН ШАТАНД ХЯНАСАН:  
 АУДИТЫН МЕНЕЖЕР  
 АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЯМ ОГНОО:

АУДИТОР

Л.МӨНХ-ОРГИЛ



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 24 өдөр

№ 25/А2260439 /ХӨА2023/49  
НА - СТА - ТЦЗ

Мөрөн сум

### Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Таван саяас дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллээс 9 удаагийн 279,063,855 (хоёр зуун далан есөн сая жаран гурван мянга найман зуун тавин таван) төгрөг, цалингийн зардлаас бусад 5 саяас дээш үнийн дүн бүхий орлогын мэдээлэл 12 удаагийн 349,377,700 (гурван зуун дөчин есөн сая гурван зуун далан долоон мянган долоон зуун) төгрөг, зарлагын 8 удаагийн 91,866,873 (ерэн нэгэн сая найман зуун жаран зургаан мянга найман зуун далан гурван) төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна.
2. Тайлант оны 4 дүгээр сард Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулах мэдээллийг огт мэдээлээгүй байна.
3. Хагас, бүтэн жилээр оруулах мэдээллээс байгууллагын батлагдсан төсөв, дараа жилийн төсвийн төслөөс бусад бүх мэдээллийг мэдээлээгүй байна.
4. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зөвлөмж хүргүүлсэн ба зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Дээрх зөрчил нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.4, 6.1.5, 6.4.3, 6.4.4, 6.4.5 дах заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тоот тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр өгөөжтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн

### ШААРДАХ нь:

1. Дээрх Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийг таслан зогсоож, цаашид хууль, журмын холбогдох заалтуудыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах

2. Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 10-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэхийг Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын дарга Ж. Амартүвшин, нягтлан бодогч П.Лувсанпэрэнлэй нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР:

Л.МӨНХ-ОРГИЛ



<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот Утас: 70384043



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 24 өдөр

№ 24/А.2.260439/ХӨА-2023/49  
#А-СТА-Т#3

Мөрөн сум

### Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчин 21,251,700 (Хорин нэгэн сая хоёр зуун тавин нэгэн мянга долоон зуун) төгрөгөөр хилийн цэсийн самбар, хаалга барьж байгуулсан зөрчил илэрлээ.

Дээрх зөрчил нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1дэх заалт “хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах,”-тай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тоот тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр өгөөжтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн

### ШААРДАХ нь:

1. Төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой зөрчлийг таслан зогсоож, цаашид Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтуудыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах;
2. Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 10-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэхийг Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын дарга Ж. Амартүвшин, нягтлан бодогч П.Лувсанпэрэнлэй нарт даалгав.

### АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

Л.МӨНХ-ОРГИЛ

<sup>1</sup>Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот Утас: 70384043